



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/617

Мөрөн сум

Мотоциклтойгоор замын хөдөлгөөнд
оролцохыг хязгаарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.2, 9.4.3, 9.4.5, Авто замын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3, 28 дугаар зүйлийн 28.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зорчих хэсгийн гадаргуу цасаар хучигдаж авто замын нөхцөл байдал хүндэрсэн үед осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, учирч болох хохирол эрсдэлийг багасгах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор мотоциклтойгоор замын хөдөлгөөнд оролцохыг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл хугацаагаар хязгаарласугай.

2.Хэрэгжилтэд хяналт тавьж, иргэдэд хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай анхааруулга, сэрэмжлүүлэг өгч, сурталчлах ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай хүргэж, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажиллахыг цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Д.Мөнхжаргал), аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс (Р.Машбат)-т тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Гансүх)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР